



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/129

Халбан

**Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг, 38.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 2-н иргэний 1527 м2 газрыг хавсралтад зааснаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг Улсын бүртгэгч (Д.Дэлгэрмөрөн), Газрын даамал (Н.Цасанчихэр) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Сумын Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор сумын Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг сумын Газрын даамал (Н.Цасанчихэр)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АНХБАЯР



Цэцэрлэг сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/129 дугаар захирамжийн хавсралт

Газар эзэмших эрхийн гэрчилгээ шилжүүлэх иргэн, ААНБ-ын жагсаалт

№	Эрх шилжүүлж байгаа иргэн ААНБ-ын нэр	Шилжүүлэн авч байгаа иргэн, ААНБ-ын нэр	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар эзэмшүүлэх хугацаа	Нэгж талбарын дугаар	Хүчингүй болгож буй захирамжийн дугаар
1	Тэс Баярсүрэн Энхсүрэн РС84101331	Омбо Тогтохын Бямбасүрэн РС83121715	Гэр, орон сууц хашааны газар	Халбан баг Халбан 7-700	978	40	6732001575	сумын Засаг даргын 2024 оны 01.04-ны өдрийн А/01 дугаар захирамжийн 5-р мөр
2	Сартуул Мягмарсүрэн Дашдондог РС63121211	Хиргис Баттогтох Балт РС71071823	Гэр, орон сууц хашааны газар	Буриа 8-806	549	40	6732001662	сумын Засаг даргын 2013.09.23-ны өдрийн А/109 тоот захирамжийн М.Дашдондог